

СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧИЙГ ТОГТООХ, БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай 2003 оны Конвенц, Монгол Улсын Үндсэн хууль, Төрөөс баримтлах соёлын бодлого, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын үзэл баримтлалд нийцүүлэн Монгол Улс дахь соёлын биет бус өв (цаашид СББӨ гэх), түүнийг өвлөн уламжлагчийг таньж тогтоох, Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан (цаашид “СӨУНБМС” гэх)-д бүртгэхэд энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Нэр томьёо

2.1 "Соёлын биет бус өв" гэж хамт олон, бүлэг, хувь хүмүүс соёлын өвийнхөө бүрэлдэхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн зан заншил, дүрслэх болон илэрхийлэх хэлбэр, уламжлалт мэдлэг, арга барил, тэдгээртэй холбоотой эд өлгийн зүйл, зэмсэг, урлагийн бүтээл, соёлын орон зайг;

2.1.1. Эх хэл, бичиг, түүний хүрээний соёл

Монгол хэл, угсаатны бүлэг, нутгийн аялгуу болон бичиг үсэг, ном судар бүтээх арга барил, зан үйл, түүний хүрээний соёл гэх мэт;

2.1.2. Аман зохиолын уламжлал, түүнийг илэрхийлэх хэлбэр

Аман билэг, үлгэр, домог, тууль, ерөөл, магтаал, зүйр цэцэн үг, ардын зан үйлийн шүлэг, сацал мялаалгын үгс, түргэн хэллэг, ардын аман болон утга зохиолын бусад бүтээл гэх мэт;

2.1.3. Урлагийн тоглох үзүүлбэр

Ардын урт, богинын дуу, хөөмий, исгэрээ, морин хуур, цуур, аман хуур зэрэг уламжлалт хөгжмийн урлаг, тууль, тэдгээрийг дуулах, хайлах арга барил, бий, биелгээ, цам зэрэг уламжлалт бүжгийн урлаг, уран нугаралт болон циркийн үзүүлбэрийг илэрхийлэх арга барил болон урлагийн тоглох үзүүлбэр гэх мэт;

2.1.4. Үндэсний хөгжмийн зэмсгийг урлах, хөгжимдөх, аялгуу тэмдэглэх арга барил

Ихэл, морин хуур, цуур, аман хуур, лимбэ зэрэг үндэсний хөгжмийн зэмсгийг урлах, хөгжимдөх арга хэлбэр, аялгуу тэмдэглэх арга барил болон үндэсний хөгжмийн урлагтай холбогдох бусад бүтээл гэх мэт;

2.1.5 Уламжлалт гар урлалын дэг сургууль, арга барил

Монгол дархан, модон эдлэлийн урлал, оёдол, хатгамал, эсгий ширмэл, арьс ширэн урлал, малын ашиг шимийг боловсруулах уламжлалт арга барил, ан

агнуурын уламжлалт арга ухаан (технологи) болон угсаатны бүлгийн гар урлалын онцлог ур хийц, арга барил, дэг сургууль, түүнийг дагалдах зан үйл гэх мэт;

2.1.6. Ардын ёс заншил, зан үйл, баяр ёслол

Уламжлалт ёс заншил, зан үйл, баяр ёслол, наадам тэдгээртэй холбогдох арга барил гэх мэт;

2.1.7 Ардын уламжлалт мэдлэг, арга ухаан

Уламжлалт сэтгэлгээ, сурган хүмүүжүүлэх арга ухаан, ардын билэг авьяас мэдлэг, арга билгийн ухаан болон түүнтэй холбогдох уламжлал, зан үйл, ёс заншил гэх мэт;

2.1.8 Ардын бэлгэдэх ёсны уламжлал

Ардын бэлгэдэл зүй, бэлгэдэх ёс түүнтэй холбогдох уламжлалт эрдэм ухаан, зан үйл, ёс заншлыг;

2.1.9. Үндэсний наадам, уламжлалт тоглоом, наадгайн зан үйл

Үндэсний наадам, уламжлалт тоглоом, наадгайн зан үйл Үндэсний уламжлалт тоглоом наадам, шагай, хорол, шатар, оньсон тоглоом, дэмбээ зэрэгтэй наадгай зан үйл, урлан бүтээх арга ухааныг;

2.1.10. Ардын уламжлалт технологи

Цагаан идээ бэлтгэх уламжлалт арга, улаан идээ боловсруулах арга ухаан, хөх идээ боловсруулах арга, хүндэтгэлийн зоог, боловсруулах бэлтгэх арга, арьс шир боловсруулах уламжлалт арга, үр тариа, жимс, ногоо суулгах, хураах, цайруулах арга гэх мэт;

2.1.11. Угийн бичиг хөтлөх уламжлал

Монгол хүний удмын сан, үе, үүсгэл, үндэс, уг язгуур, угсаа төрөл, удам угсаа, түүгээр дамжих бэлгэ тэмдэг, удам судрыг дуудах соёл, угийн бичиг хөтлөх уламжлал, зан үйлийг хийх;

2.1.12. Уламжлалт шашин, шүтлэгийн зан үйл, ёс заншил

Уламжлалт шашин, монгол бөө, бурхны шашин болон шашин шүтлэгийн зан үйл, дэг сургууль, ёс заншлыг;

2.1.13. Байгаль сав ертөнцийн тухай мэдлэг, зан үйл

Газар, ус, тэнгэрийн байдал, цаг агаарыг шинжлэн, байгаль дэлхийтэй харьцах уламжлалт мэдлэг, чадварын олон хэлбэр, тахилгат газар, байгаль хамгаалах уламжлалтай холбогдох өвийг;

2.1.14 Газар усны нэр

Газар, усны уламжлалт нэрийн тухай хууч яриа, бэлгэдэл зүй, цээрийн ёс гэх мэт;

2.1.15. Бусад соёлын биет бус өв.

2.2 “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч” гэж СББӨ-ийг өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн, түүнийгээ олны хүртээл болгож, дараагийн үедээ өвлүүлэн уламжлуулж байгаа хамт олон, бүлэг, хувь хүнийг;

2.3 “Соёлын биет бус өвийн мэргэжлийн зөвлөл” гэж СББӨ-ийг хамгаалах, бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох санал, дүгнэлт танилцуулах, судалгааны ажил хийх зөвшөөрөл олгох чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл

2.4 “Соёлын биет бус өвийн зөвлөл” гэж аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх соёлын нэгжийн дэргэд СББӨ-ийг таньж, тогтоох, бүртгэх, өвлөн уламжлагчийг алдаршуулахтай холбоотой асуудлаар санал, зөвлөмж өгөх чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг;

2.5 “Соёлын биет бус өвийн Төлөөллийн бүртгэл” гэж өвлөн уламжлагч, бүлэг, хамт олон болон олон нийтийн дунд нийгэм, соёлын өндөр ач холбогдолтой, соёлын орон зайдаа харьцангуй тогтвортой оршиж, үйлдэгдэж буй СББӨ-ийн бүртгэлийг;

2.6 “Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн бүртгэл” өвлөн уламжлагч хувь хүн эсвэл хамт олон, болон оролцогч талын хүчин чармайлтаас үл хамааран өвийн оршин тогтнох чадвар нь устах эрсдэлд орсон, яаралтай авран хамгаалах шаардлагатай болсон өвийн төрөл зүйл; эсхүл хамгаалах арга хэмжээ нэн даруй авахгүй тохиолдолд өвийг авран хамгаалах боломжгүй болох ноцтой аюул нүүрлэсэн учир хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай болсон өвийн бүртгэлийг;

2.7 “Соёлын биет бус өвийн хадгалалт, хамгаалалтын шилдэг туршлагын бүртгэл” гэж өвлөн уламжлагч хувь хүн эсвэл хамт олон, болон оролцогч талуудад СББӨ, түүнтэй холбоотой дадал, мэдлэгийг өвлүүлэн уламжлуулахад тулгарсан бэрхшээлийг хэрхэн амжилттай даван туулж, хамгаалсан талаарх туршлагыг хуваалцах зориулалт бүхий бүртгэлийг;

2.8 “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн жагсаалт” гэж аймаг, нийслэлийн соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангаас тус санд бүртгэгдсэн өвлөн уламжлагчдын өвийг эзэмшсэн арга барил, ур чадвар, сургасан шавийн тоо, өвийн төрөл зүйлийг үеэс үед өвлөн уламжилсан байдал, дотоодын уралдаан, тэмцээнд үзүүлсэн амжилт зэргийг харгалзан үзсэний үр дүнд шалгаруулсан, аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар баталсан жагсаалтыг;

2.9 “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт” гэж аймаг, нийслэлийн “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн жагсаалт”-аас нэр дэвшүүлсэн өвлөн уламжлагчийн өвийг эзэмшсэн арга барил, ур чадвар, өвийн төрөл зүйлийг үеэс үед өвлөн уламжилсан байдал, сургасан шавийн тоо, дотоод, гадаадын уралдаан, тэмцээнд үзүүлсэн амжилт зэргийг харгалзан үзсэний үр дүнд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эцэслэн боловсруулж “Соёлын биет бус өвийн мэргэжлийн зөвлөл”-өөр хэлэлцүүлэн, Засгийн газрын тогтоолоор баталсан жагсаалтыг;

2.10 “Соёлын биет бус өвийг өвлөн суралцагч” (цаашид өвлөн суралцагч гэх) гэж Монгол Улсын “Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл”, “Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл”, “Соёлын биет бус өвийн хадгалалт, хамгаалалтын шилдэг туршлагын бүртгэл”-д бүртгэгдсэн өвийн төрөл зүйлийг өвлөн суралцаж буй, соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд бүртгэгдсэн хувь хүн, хамт олон, бүлэг хүнийг ойлгоно.

Гурав. СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийг таньж тогтоох

3.1. СББӨ, түүнийг өвлөн уламжлагч (мөн өвлөн суралцагч)-ийг тухайн орон нутаг, соёлын орон зайд хамаарал бүхий хувь хүн, хамт олон, бүлэг хүмүүс тодорхойлж, таньж тогтоож болно.

3.2. “Соёлын биет бус өвийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх журам”-ын дагуу зөвшөөрөл авсан судлаач, эрдэм шинжилгээний байгууллага, судалгааны баг болон хамтарсан баг СББӨ, түүнийг өвлөн уламжлагч (мөн өвлөн суралцагч)-ийг таньж тогтоож болно.

Дөрөв. СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийг бүртгэх

4.1 “Соёлын биет бус өвийн бүртгэл”-ийн маягт (хавсралт 1), “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн бүртгэл”-ийн маягт (хавсралт 2)-ыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн Газрын гишүүн батална.

4.2. Маягтыг хөтлөхтэй холбогдох “бүртгэл хөтлөх заавар”-ыг Соёлын өвийн үндэсний төв боловсруулж, батлан, шат шатны бүртгэл мэдээллийн сан, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх соёлын нэгжид сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна.

4.3 СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэлийг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.1 дэх хэсэгт заасан тогтолцооны дагуу бүртгэлийн маягтыг ашиглан соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд бүртгэнэ.

4.4 Сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн санд СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийг бүртгэх үйл ажиллагаанд аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх соёлын нэгж оролцож, дэмжлэг үзүүлж ажиллана.

4.5 Сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэхийг хүсэгч (хувь хүн, бүлэг, хамт олон) нь өргөдлөө бүртгэлийн маягтын дагуу харьяа сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн санд гаргана. Өргөдлийн маягт нь олон нийтэд нээлттэй байна.

4.6 СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэлийг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.2 дахь хэсэгт заасны дагуу хадгална.

4.7 СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэл, тоон дүн, мэдээ, өөрчлөлт, шилжилт хөдөлгөөн, нэмэлт баяжилтын талаарх мэдээллийг шат шатны бүртгэл мэдээллийн сан Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 23.2 дахь хэсэгт заасны дагуу тайлагнана.

Тав. Бүртгэлийн бүрдэл

5.1 Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 21.2 дэхь хэсэгт заасны дагуу бүртгэлийн бүрдлийг бүрдүүлж хадгална.

5.2 Бүртгэлийн бүрдлийг “бүртгэл хөтлөх заавар”-т заасны дагуу өндөр чанартай бэлтгэж, бүртгэлд хавсаргана.

Зургаа. Бүртгэл, жагсаалт батлах

6.1. “Соёлын биет бус өвийн Төлөөллийн бүртгэл”, “Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн бүртгэл”, “Хадгалалт, хамгаалалтын шилдэг туршлагын бүртгэл”, “Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн өвлөн уламжлагчийн жагсаалт”-ыг аймаг, нийслэлийн болон үндэсний гэсэн 2 ангиллаар батална.

6.2 Аймаг, нийслэлийн бүртгэл, жагсаалт

6.2.1 Аймаг, нийслэлийн “Соёлын биет бус өвийн Төлөөллийн бүртгэл”, “Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн бүртгэл”, “Соёлын биет бус өвийн хадгалалт, хамгаалалтын шилдэг туршлагын бүртгэл”, “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн жагсаалт”-ыг аймаг, нийслэлийн Засаг дарга 3 жил тутамд зохион байгуулагддаг “Соёлын биет бус өвийн улсын үзлэг”-ийн үр дүнтэй уялдуулан, шинэчлэн батална.

6.2.2 Аймаг, нийслэлийн Засаг дарга нь дээрх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх “Соёлын биет бус өвийн зөвлөл”-ийг байгуулан ажиллана. Зөвлөлийн дарга нь аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Соёлын нэгжийн дарга, нарийн

бичгийн дарга нь соёлын нэгжийн соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн, гишүүд нь СББӨ-ийн чиглэлээр мэргэшсэн эрдэмтэн, судлаач, төрийн болон ТББ-ын төлөөлөл байна.

6.2.3 Аймаг, нийслэлийн бүртгэл, жагсаалтад оруулах өв, өвлөн уламжлагчийн бүртгэл, материалыг боловсруулж, шалгуур үзүүлэлтийн дагуу шалгаруулах үйл ажиллагааг аймаг, нийслэлийн бүртгэл мэдээллийн сан, аймаг, нийслэлийн соёлын нэгж, “Соёлын биет бус өвийн зөвлөл” хамтран Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 26.1 дэх хэсэгтэй уялдуулан 3 жил тутамд зохион байгуулж, санал дүгнэлтийг Засаг даргад хүргүүлнэ.

6.2.4 Аймаг, нийслэлийн бүртгэл, жагсаалтаас үндэсний бүртгэл, жагсаалтад нэр дэвшүүлэх СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийн урьдчилсан санал, холбогдох материалыг аймаг, нийслэлийн бүртгэл, мэдээллийн сан, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх “Соёлын биет бус өвийн зөвлөл” боловсруулж Засаг даргын дэргэдэх соёлын нэгжид танилцуулна.

6.2.5. Аймаг, нийслэлийн Засаг дарга болон Засаг даргын дэргэдэх соёлын нэгж ирсэн саналыг нягтлан үзэж, хэлэлцээд үндэсний жагсаалтад нэр дэвшүүлэх өв, өвлөн уламжлагчийн санал дүгнэлтийг холбогдох баримт, материал, хэрэглэгдэхүүн (баримтат кино, DVD, VCD, CD, аудио хуурцаг, ердийн болон дижитал гэрэл зураг, зураглал, тэмдэглэл, биет нотлох эд зүйлс гэх мэт)-ийг санал, дүгнэлтийн хамт тухайн жилийн 10 дугаар сарын 01-ний дотор Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлнэ.

6.3 Үндэсний бүртгэл, жагсаалт

6.3.1 Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 13.1.8 дахь хэсэгт заасны дагуу “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт”-ыг Монгол Улсын Засгийн газар батална.

6.3.2 “Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл”, “Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл”, “Соёлын биет бус өвийн хадгалалт, хамгаалалтын шилдэг туршлагын бүртгэл”-ийг Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.3.3 Аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын дэргэдэх соёлын нэгжээс үндэсний жагсаалтад нэр дэвшүүлсэн СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийн материалыг Соёлын өвийн үндэсний төв хүлээн авч, салбар зөвлөлөөрөө хэлэлцүүлэн, бүртгэл, жагсаалтыг урьдчилсан байдлаар боловсруулж, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх “Соёлын биет бус

өвийн мэргэжлийн зөвлөл”-өөр хэлэлцүүлэхэд бэлтгэнэ. Урьдчилсан жагсаалтыг “Соёлын биет бус өвийн үзлэг”-ийн үр дүнтэй заавал уялдуулсан байна.

6.3.4 “Соёлын биет бус өвийн мэргэжлийн зөвлөл” нь Соёлын өвийн үндэсний төвөөс бэлтгэн ирүүлсэн үндэсний бүртгэл, жагсаалтад нэр дэвшүүлсэн өв, өвлөн уламжлагчийн материалыг хянан хэлэлцээд, 11 дүгээр сарын 01-ний дотор Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд санал, дүгнэлтийг хүргүүлнэ.

6.3.5 Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн “Соёлын биет бус өвийн мэргэжлийн зөвлөл”-ийн санал, дүгнэлтийг үндэслэн 12 дугаар сарын 01-ний дотор “Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл”, “Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл”, “Соёлын биет бус өвийн хадгалалт, хамгаалалтын шилдэг туршлагын бүртгэл”-ийг батална.

6.3.6 Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн “Соёлын биет бус өвийн мэргэжлийн зөвлөл”-ийн санал, дүгнэлтийг үндэслэн “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт” батлах тухай тогтоолын төслийг боловсруулан, Засгийн газарт өргөн барина.

6.3.7 Аймаг, нийслэлээс үндэсний бүртгэл, жагсаалтад нэр дэвшүүлсэн өв, өвлөн уламжлагчийн холбогдох материал, хэрэглэгдэхүүн (баримтат кино, DVD, VCD, CD, аудио хуурцаг, ердийн болон дижитал гэрэл зураг, гар бичмэл, тэмдэглэл, бүтээл гэх мэт) болон “Соёлын биет бус өвийн мэргэжлийн зөвлөл”-ийн шалгаруулалтын үеэр хийсэн бичлэг, тэмдэглэл зэрэг бусад материалыг зохих журмын дагуу Соёлын өвийн үндэсний төвд архивлан хадгална.

Долоо. Бүртгэл, жагсаалтад бүртгэх шалгуур үзүүлэлт

7.1 Аймаг нийслэлийн бүртгэл, жагсаалтад бүртгэх, шалгуур үзүүлэлт

7.1.1 “Соёлын биет бус өвийн Төлөөллийн бүртгэл”-д бүртгэлд бүртгэх шалгуур үзүүлэлт

7.1.1.1 Тус өвийн зүйл нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 3.1.5 болон 7 дахь хэсэгт тодорхойлсон СББӨ-ийг багтаан илэрхийлсэн байх;

7.1.1.2 Өвийн төрөл, зүйл нь хувь хүн, бүлэг, хамт олны (соёлын хам бүлэг, угсаатны бүлэг) ахуй амьдрал, зан заншил, уламжлалт мэдлэг, туршлагын салшгүй нэг хэсэг байх,

7.1.1.3 Өвийн төрөл, зүйл нь хувь хүн, бүлэг, хамт олны (соёлын хам бүлэг, угсаатны бүлэг) ахуй амьдралд үйлдэгдэж (хэрэглэгдэж), үеэс үед тасралтгүйгээр өвлөгдөн уламжлагдсан байх,

7.1.1.4 Тухайн орон нутгийн байгаль, цаг уур, газарзүйн байршилтай нягт уялдсан, хувь хүн, бүлэг, хамт олны (угсаатны бүлэг, соёлын хам бүлэг) амьдрал ахуйн онцлогийг бүрэн илэрхийлсэн байх,

7.1.1.5 Өвийн төрөл, зүйлийг бүртгэхийг өвлөн уламжлагч, хамт олон, бүлэг чөлөөтэй зөвшөөрсөн байх,

7.1.1.6 СББӨ, угсаатан зүй, нийгэм-соёлын антропологи, Монгол судлал, хэл, аман зохиолын хүрээний судалгааны эргэлтэд орсон байх,

7.1.1.7 Өвийн төрөл, зүйлийн нийгэм, соёлын ач холбогдлыг шинжлэх ухааны үндэстэй тодорхойлж, судалсан байх,

7.1.1.8 Өвийн төрөл, зүйлийн нийгэм, соёлын ач холбогдол өндөр байх,

7.1.1.9 Соёлын биет бус өвийн олон төрөл зүйл, ай савтай нягт уялдаатай байх,

7.1.1.10 Өвлөн уламжлагч, бүлэг, хамт олны бүтээлч чадавхыг нотлон харуулсан байх,

7.1.1.11 Өвийн тархцыг өвлөн уламжлагчийн бүртгэлд үндэслэн газарзүйн байршил, шилжилт хөдөлгөөний мэдээллийн хамт тодорхойлсон байх,

7.1.1.12 Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд тус өвийг өвлөн уламжлагч хангалттай хэмжээнд бүртгэгдсэн байх.

7.1.1.13 Өвийн оршин тогтнох чадвар ямар нэгэн аюул заналхийлэлд өртөөгүй байх.

7.1.1.14 Аймаг, орон нутгийн байгаль, газарзүйн тогтоц, уур амьсгалын онцлог болон хувь хүн, бүлэг, хамт олны ахуй амьдралын онцлогтой уялдан бий болсон соёл, уламжлал, зан үйл, амьдралын хэв маяг, уламжлалт мэдлэг, туршлагыг үндэсний хэмжээнд төлөөлөхүйц байх,

7.1.2 “Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн бүртгэл”-д бүртгэх шалгуур үзүүлэлт.

7.1.2.1 тухайн өвийг өвлөн уламжлагч хамт олон, бүлэг, хувь хүмүүс тус бүртгэлд өвийг нэр дэвшүүлэхийг чөлөөтэй зөвшөөрсөн байх,

7.1.2.2 өвлөн уламжлагчийн тоо цөөрсөн, нас өндөр болсон, нас барсан зэрэг шалтгааны улмаас өвийг үйлдэх давтамж буурсан,

7.1.2.3 өвлөн уламжлагч хувь хүн эсвэл хамт олон, болон оролцогч талын хүчин чармайлтаас үл хамааран өвийн оршин тогтнох чадвар нь устах эрсдэлд орсон,

7.1.2.4 Нэн яаралтай авран хамгаалах арга хэмжээ авахгүй тохиолдолд өвийг авран хамгаалах боломжгүй болох ноцтой аюул нүүрлэсэн,

7.1.2.5 Аймаг, нийслэл, орон нутгийн хэмжээнд нэн яаралтай авран хамгаалах, сэргээн амьлуулах төлөвлөгөө хэрэгжүүлж байгаа эсэх,

7.1.3 “Соёлын биет бус өвийн хадгалалт, хамгаалалтын шилдэг туршлагын бүртгэл”-д бүртгэх шалгуур үзүүлэлт.

7.1.3.1 Өвлөн уламжлагч, бүлэг, хамт олон болон оролцогч талууд хамтран тухайн өвийг хамгаалах, өвлүүлэн уламжлуулах, сурталчлах чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа зохион байгуулдаг байх,

7.1.3.2 Өвийг хамгаалахад тулгарсан бэрхшээлийг оновчтой шийдэж, өвийн оршин тогтнох чадварыг бэхжүүлсэн байх,

7.1.4. “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн жагсаалт”

7.1.4.1 Өвлөн уламжлагчийн ур чадвар,

7.1.4.2 Өвийн төрөл зүйлийг үеэс үед өвлөн уламжилсан байдал

7.1.4.3 Сургасан шавийн тоо,

7.1.4.4 Өвийг эзэмшсэн арга барил,

7.1.4.5 Эзэмшсэн өвийг өвлүүлэн уламжлуулах арга барил, туршлага

7.1.4.6 Дотоодын уралдаан, тэмцээнд үзүүлсэн амжилт

7.2 Үндэсний бүртгэл, жагсаалтад бүртгэх, шалгуур үзүүлэлт

7.2.1 “Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл”-д бүртгэлд СББӨ-г бүртгэх шалгуур үзүүлэлт.

7.2.1.1 Өвийн төрөл, зүйл нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 3.1.5 болон 7 дахь хэсэгт тодорхойлсон СББӨ-ийг багтаан илэрхийлсэн байх;

7.2.1.2 Өвийн төрөл, зүйл нь хувь хүн, бүлэг, хамт олны (соёлын хам бүлэг, угсаатны бүлэг) ахуй амьдрал, зан заншил, уламжлалт мэдлэг, туршлагын салшгүй нэг хэсэг байх,

7.2.1.3 Өвийн төрөл, зүйл нь хувь хүн, бүлэг, хамт олны (соёлын хам бүлэг, угсаатны бүлэг) ахуй амьдралд үйлдэгдэж (хэрэглэгдэж), үеэс үед тасралтгүйгээр өвлөгдөн уламжлагдсан байх,

7.2.1.4 Тухайн орон нутгийн байгаль, цаг уур, газарзүйн байршилтай нягт уялдсан, хувь хүн, бүлэг, хамт олны (угсаатны бүлэг, соёлын хам бүлэг) амьдрал ахуйн онцлогийг бүрэн илэрхийлсэн байх,

7.2.1.5 Өвийн төрөл, зүйлийг бүртгэхийг өвлөн уламжлагч, хамт олон, бүлэг чөлөөтэй зөвшөөрсөн байх,

7.2.1.6 СББӨ, угсаатан зүй, нийгэм-соёлын антропологи, Монгол судлал, хэл, аман зохиолын хүрээний судалгааны эргэлтэд орсон байх,

7.2.1.7 Өвийн төрөл, зүйлийн нийгэм, соёлын ач холбогдлыг шинжлэх ухааны үндэстэй тодорхойлж, судалсан байх,

7.2.1.8 Өвийн төрөл, зүйлийн нийгэм, соёлын ач холбогдол өндөр байх,

7.2.1.9 СББӨ-ийн олон төрөл зүйл, ай савтай нягт уялдаатай байх,

7.2.1.10 Өвлөн уламжлагч, бүлэг, хамт олны бүтээлч чадавхыг нотлон харуулсан байх,

7.2.1.11 Өвийн тархцыг өвлөн уламжлагчийн бүртгэлд үндэслэн газарзүйн байршил, шилжилт хөдөлгөөний мэдээллийн хамт тодорхойлсон байх,

7.2.1.12 Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд тус өвийг өвлөн уламжлагч хангалттай хэмжээнд бүртгэгдсэн байх,

7.2.1.13 Өвийн оршин тогтнох чадвар ямар нэгэн аюул заналхийлэлд өртөөгүй байх,

7.2.1.14 Монгол үндэстний соёл, уламжлал, зан заншил, амьдралын хэв маяг, уламжлалт мэдлэг, туршлагыг олон улсад төлөөлөхүйц байх,

7.2.2 “Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл”-д СББӨ-ийг бүртгэх шалгуур үзүүлэлт.

7.2.2.1 тухайн өвийг өвлөн уламжлагч хамт олон, бүлэг, хувь хүмүүс тус бүртгэлд өвийг нэр дэвшүүлэхийг чөлөөтэй зөвшөөрсөн байх,

7.2.2.2 өвлөн уламжлагчийн тоо цөөрсөн, нас өндөр болсон, нас барсан зэрэг шалтгааны улмаас өвийг үйлдэх давтамж буурсан,

7.2.2.3 өвлөн уламжлагч хувь хүн эсвэл хамт олон болон оролцогч талын хүчин чармайлтаас үл хамааран өвийн оршин тогтнох чадвар устах эрсдэлд орсон,

7.2.2.4 Нэн яаралтай авран хамгаалах арга хэмжээ авахгүй тохиолдолд өвийг авран хамгаалах боломжгүй болох ноцтой аюул нүүрлэсэн,

7.2.2.5 Үндэсний хэмжээнд нэн яаралтай авран хамгаалах, сэргээн амьлуулах төлөвлөгөө хэрэгжүүлж байгаа эсэх,

7.2.3 “Соёлын биет бус өвийн хадгалалт, хамгаалалтын шилдэг туршлагын үндэсний бүртгэл”-д СББӨ-ийг бүртгэх шалгуур үзүүлэлт.

7.2.3.1 Өвлөн уламжлагч, бүлэг, хамт олон болон оролцогч талууд хамтран тухайн өвийг хамгаалах, өвлүүлэн уламжлуулах, сурталчлах чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа зохион байгуулдаг байх,

7.2.3.2 Өвийг хамгаалахад тулгарсан бэрхшээлийг оновчтой шийдэж, өвийн оршин тогтнох чадварыг бэхжүүлсэн байх,

7.2.4. “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн жагсаалт”

7.2.4.1 Өвлөн уламжлагчийн ур чадвар,

7.2.4.2 Өвийн төрөл зүйлийг үеэс үед өвлөн уламжилсан байдал

7.2.4.3 Сургасан шавийн тоо,

7.2.4.4 Өвийг эзэмшсэн арга барил,

7.2.4.5 Эзэмшсэн өвийг өвлүүлэн уламжлуулах арга барил, туршлага

7.2.4.6 Дотоодын уралдаан, тэмцээнд үзүүлсэн амжилт

7.2.4.7 Гадаадын уралдаан, тэмцээнд үзүүлсэн амжилт

Найм. Бүртгэл, жагсаалтад өөрчлөлт оруулах

8.1 “Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл”-д бүртгэгдсэн өвийн оршин тогтнох чадвар эрсдэлд орсон, өвлөн уламжлагчийн тоо цөөрсөн, өвийн нийгэм, соёлын ач холбогдол буурсан зэрэг тохиолдолд өвийн оршин тогтнох чадварыг тодорхойлох “үнэлгээ, судалгаа”-г холбогдох мэргэжлийн судлаач, судалгааны баг, судалгааны хүрээлэнгээр хийлгэх ба тус үнэлгээ, судалгааны

ажлын санал, дүгнэлтийг үндэслэн өвийг “Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл”-д шилжүүлж болно.

8.2 “Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл”-д бүртгэгдсэн өвийн оршин тогтнох чадвар бэхэжсэн, тухайлбал өвлөн уламжлагчийн тоо нэмэгдсэн, өвийн нийгэм, соёлын ач холбогдол өссөн, өвийг үйлдэх давтамж тогтворжин нэмэгдсэн зэрэг тохиолдолд өвийн оршин тогтнох чадварыг тодорхойлох “үнэлгээ, судалгаа”-г холбогдох мэргэжлийн судлаач, судалгааны баг, судалгааны хүрээлэнгээр хийлгэх ба тус үнэлгээ, судалгааны ажлын санал, дүгнэлтийг үндэслэн өвийг “Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл”-д шилжүүлж болно.

8.3 СББӨ-ийн улсын үзлэгийн үр дүн болон аймаг, нийслэлээс нэр дэвшүүлсэн өв, өвлөн уламжлагчийн материалд дүн шинжилгээ хийж, “Соёлын биет бус өвийн мэргэжлийн зөвлөл”-өөр хэлэлцүүлсний үр дүнд “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт”-д өөрчлөлт оруулах санал, дүгнэлтийг гаргана.

8.4 Жагсаалт шинэчлэхдээ нас барсан өвлөн уламжлагчийг “идэвхгүй жагсаалт” руу шилжүүлж, шалгуур хангасан өвлөн уламжлагчийг шинээр нэмнэ.

8.5 Аймаг, нийслэлийн болон үндэсний жагсаалтад бүртгэгдсэн өвийг үйлдэх туршлага тасарсан, өвлөн уламжлагч бүртгэгдээгүй, өвийн нийгэм, соёлын ач холбогдол буурсан, өнөөгийн амьдралын хэв маягт сөрөг нөлөө үзүүлэх болсон зэрэг тохиолдолд тухайн СББӨ-ийг жагсаалтаас хасч болно. Жагсаалтаас хасах өвийн нийгэм, соёлын ач холбогдол, нөлөөллийн судалгаа, үнэлгээг мэргэжлийн судалгааны хүрээлэн, судлаач, судалгааны багаар хийлгэж, судалгааны санал дүгнэлтэд үндэслэн жагсаалтаас хасах санал дүгнэлтийг аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх “Соёлын биет бус өвийн зөвлөл”, Соёлын яамны дэргэдэх “Соёлын биет бус өвийн мэргэжлийн зөвлөл”-ийн гаргана.

8.6 Аймаг, нийслэлийн Засаг дарга, засаг даргын дэргэдэх соёлын нэгж, “Соёлын биет бус өвийн зөвлөл” нь энэ журмын 8.1, 8.2, 8.3, 8.4, 8.5 дахь хэсгийг үндэслэн аймаг, нийслэлийн СББӨ-ийн бүртгэл болон өвлөн уламжлагчийн жагсаалтад өөрчлөлт оруулж, шинэчлэгдсэн бүртгэл, жагсаалтаас үндэсний бүртгэл, жагсаалтад өв болон өвлөн уламжлагчийг 3 жилд нэг удаа нэр дэвшүүлнэ.

Ес. СББӨ-ийг өвлөн уламжлагчийн эрх, үүрэг

9.1 Өвлөн уламжлагчийн эрх

9.1.1 Өвлөн уламжлагч (хувь хүн, бүлэг хүмүүс, хамт олон) нь өөрийн эзэмшсэн СББӨ, онцгой авьяас чадвараа хувийн өмч биш, харин ард түмний олон зуун жил эзэмшиж ирсэн соёлын өв гэж үзэхийн хамт түүнийг илэрхийлэх, сурталчлах, тоглох, үзүүлбэрт оролцох, үзэсгэлэн гаргах, музей, клуб, хамтлаг байгуулах, сургалт, сурталчилгаа зэрэг үйл ажиллагааг холбогдох эрх зүйн орчны хүрээнд эрхлэх;

9.1.2 Өвлөн уламжлагч нь өөрийн үйл ажиллагааны талаарх санал, хүсэлтээ бүх шатны соёлын асуудал эрхэлсэн төрийн байгууллага болон холбогдох бусад байгууллагад уламжлах;

9.1.3 Өвлөн уламжлагч нь өөрийн эзэмшсэн СББӨ, онцгой авьяас чадварын талаар судалгаа, сурталчилгааны бүтээл туурвих, хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, тоглолт, үзүүлбэрээр олон нийтэд сурталчлах, энэ талаар төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүмүүстэй хамтарч ажиллах;

9.1.4 Өвлөн уламжлагч нь ур чадвараа дээшлүүлэх, ур чадварын шатлал зэрэглэлийг ахиулах,

9.1.5 Өөрийн авьяас, ур чадвараа мэргэжлийн сургалт болон шавь сургалтаар дамжуулан залуу хойч үед өвлүүлэн уламжлуулах эрхтэй.

9.2 Өвлөн уламжлагчийн үүрэг

9.2.1 Өөрийн эзэмшсэн СББӨ, авьяас чадвар, ялангуяа мартагдаж, устаж үгүй болоход хүрээд буй өвийг өвлөн суралцагчдаа язгуур байдлаар нь өвлүүлэх;

9.2.2 СББӨ-ийг хадгалж хамгаалах талаар санаачлагатай ажиллаж, орон нутаг, улс, олон улс, тив, дэлхийн шинж чанартай СББӨ-ийн, наадам, фестиваль, үзэсгэлэн, яармагт оролцох;

9.2.3 Өвлөн уламжилсан онцгой авьяас чадвар, уламжлалт мэдлэгээ орчин цагийн хэрэгцээ, шаардлага, шинжлэх ухаан, дэвшилтэд технологитой хослуулан хөгжүүлэх;

Арав. Өвлөн уламжлагчийг алдаршуулах, дэмжлэг үзүүлэх

10.1 “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт”-д багтсан өвлөн уламжлагчид батламж, энгэрийн тэмдэг олгож, алдаршуулах үйл ажиллагааг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

10.2 “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт”-д багтсан өвлөн уламжлагчид олгох батламж, энгэрийн тэмдгийн загварыг Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн жагсаалт”-д багтсан өвлөн уламжлагчид олгох батламж, энгэрийн тэмдгийн загварыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

10.3 Аймаг, нийслэлийн Засаг дарга нь “СББӨ-ийг өвлөн уламжлагч”-д олгох батламж, энгэрийн тэмдгийг батлагдсан загварын дагуу хэвлэж, өвлөн уламжлагчийг алдаршуулах үйл ажиллагааг аймаг, нийслэлийн соёлын нэгжтэй хамтран зохион байгуулна.

10.4 Аймаг, нийслэлийн Засаг дарга нь Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16.1.12, 39.3 дахь хэсэгт заасны дагуу СББӨ-ийг өвлөн уламжлагчид дэмжлэг үзүүлж, урамшуулал олгоно.

10.5 Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт”-д багтсан өвлөн уламжлагчийг алдаршуулах, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны төв байгууллага болон төр, хувийн хэвшил хамтран зохион байгуулна.

Арван нэг. Мэдээлэл нууцлах, ашиглах

11.1 Байгууллага, иргэдийн хүсэлтээр соёлын өвийн бүртгэлийн нууцыг чандлан хадгалах бөгөөд дуу, дүрс бичлэг хийсэн байгууллага, хүмүүсийн зохиогчийн эрхийг холбогдох хууль, журмын дагуу хамгаална.

11.2 СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийн бүртгэл, мэдээллийг зөвхөн хадгалалт, хамгаалалт, шинжлэх ухааны судалгаа, шинжилгээ, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглуулна.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН БҮРТГЭЛ

УБМС-ийн дугаар _____

Соёлын биет бус өвийн нэр _____

1	Сум, дүүргийн нэр						
2	Аймаг, нийслэлийн нэр						
3	Улсын нэр						
4	Монгол Улсын Соёлын биет бус өвийн бүртгэлийн төрөл						
	○ Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл	○ Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл				○ Бүртгэгдээгүй	
5	Хамаарах соёлын биет бус өвийн ай сав						
	○ 1	○ 2	○ 3	○ 4	○ 5	○ 6	○ 7
6	Өвийн оноосон нэр						
7	Өвийн тодорхойлолт						
8	Өвийн тархац						
9	Аймаг, нийслэлийн Соёлын биет бус өвийн жагсаалтын төрөл						
	○ Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл	○ Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэл				○ Бүртгэгдээгүй	
10	Хамгаалалтын арга хэмжээ		/Тухайн өвийг хамгаалах чиглэлээр хийсэн үйл ажиллагааны үр дүнг тодорхойлж тайланг тоймлон жил бүр нэмж бичнэ/				

Бүртгүүлэхийг зөвшөөрсөн засаг захиргааны байгууллагын эрх бүхий этгээд:

_____ / Овог. нэр/ _____ /Албан газрын нэр. албан тушаал/

Бүртгэсэн:

_____ / Овог, нэр/ _____ /Албан газрын нэр, албан тушаал/

/20.... оны сарын -ны өдөр/

Байгууллага, сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын нэгдсэн (доогуур зур) бүртгэл-мэдээллийн санд хадгалагдаж байгаа:

Д/д	Нэр төрөл	Тоо ширхэг	Хэмжээ GB	Хадгаламжийн дугаар, БМСангийн байршил
1	Цахим баримт /Гэрэл зураг, дүрс бичлэг/			
2	Цаасан, хэвлэмэл баримт			
3	Бусад / Негатив хальс, Дуу, дүрс бичлэгийн хуурцаг, CD/DVD/BD гэх мэт/			

Бүрдүүлэлт хийсэн:

_____ / _____
 / Овог, нэр/ /Албан газрын нэр, албан тушаал/

/20.... оны сарын -ны өдөр/

**МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ
ӨВЛӨН УЛАМЖЛАГЧИЙН БҮРТГЭЛ**

УБМС-ийн дугаар _____

Эзэмшсэн өвийн нэр _____

1. Өвлөн уламжлагчийн үндсэн мэдээлэл:

1	Ургийн овог							Гэрэл зураг /3x4/
2	Эцэг(эх)-ийн нэр							
3	Өөрийн нэр							
4	Хүйс							
5	Яс үндэс							
6	Төрсөн он							
7	Регистрийн дугаар							
8	Үндсэн захиргаа							
9	Оршин суугаа хаяг							
10	Утасны дугаар							
11	Мэргэжил							
12	Боловсролын түвшин							
	Боловсролгүй	бага	Бүрэн бус дунд	Бүрэн дунд	Тусгай дунд	Дээд		
13	Ажил эрхлэлтийн байдал							
	Төрийн байгууллага	Хувийн хэвшлийн байгууллага	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Малчин	Ажилгүй	Оюутан	Сурагч	Тэтгэвэрт
14	Гавьяа, шагнал		/Салбарын болон Төрийн шагналыг хамааруулна/					
15	Амжилт /Бүсийн, Үндэсний, Олон улсын уралдаан, наадам, үзэсгэлэнд оролцсон тухай мэдээлэл, гаргасан амжилт/							
16	Хөгжлийн бэрхшээлтэй эсэх				○ Тийм		○ Үгүй	
17	Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн өвлөн уламжлагчийн жагсаалтад орсон эсэх							
	○ “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт”-д бүртгэгдсэн			○ Аймаг, Нийслэлийн “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн жагсаалт”-д бүртгэгдсэн				○ Бүртгэгдээгүй

2. Өвийн тухай мэдээлэл:

1	Эзэмшсэн өвийн нэр	
2	Уламжилсан хэлбэр /Зөвхөн Уртын дуу, Хөөмэй, Морин хуур ... өвд хамаарна./	
	○ Уламжлалт шавь сургалтаар (албан бус)	○ Академик буюу танхимын сургалтаар (албан)

3	Хэзээ, хэнээс сурсан (хэд дэх үеийн өвлөн уламжлагч)	
4	Өвийн онцлог	
5	Урын сангийн мэдээлэл	
6	Хэрхэн гүйцэтгэдэг вэ? /холбогдох ёс, журам, зан үйл/	
7	Өвлүүлсэн байдал /шавь сургасан эсэх/	
8	Хавсарсан өвийн нэрс	
9	Ур чадварын түвшин	Аймаг, Нийслэл, СӨҮТ-ын дэргэдэх зөвлөл, Соёлын яамны дэргэдэх мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэнэ.

Бүртгүүлэхийг зөвшөөрсөн хамт олон, хувь хүн:

_____ / _____
/ Овог, нэр/ /Албан газрын нэр, албан тушаал/

Бүртгэсэн:

_____ / _____
/ Овог, нэр/ /Албан газрын нэр, албан тушаал/
/20.... оны сарын -ны өдөр/

Байгууллага, сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын нэгдсэн (доогуур зур) бүртгэл-мэдээллийн санд хадгалагдаж байгаа:

Д/д	Нэр төрөл	Тоо ширхэг	Хэмжээ GB	Хадгаламжийн дугаар, БМСангийн байршил
1	Цахим баримт /Гэрэл зураг, дүрс бичлэг/			
2	Цаасан, хэвлэмэл баримт			
3	Бусад / Негатив хальс, Дуу, дүрс бичлэгийн хуурцаг, CD/DVD/BD гэх мэт/			

Бүрдүүлэлт хийсэн:

_____ / _____
/ Овог, нэр/ /Албан газрын нэр, албан тушаал/
/20.... оны сарын -ны өдөр/